


Батлав:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын дарга:...../А.Энхбат/

Хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Эрд хул” ХХК-ийн захирал:...../Б.Соёлмаа/



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ЦОЦГОНЫ МУХАР, БАГАНАЙМГАНЫ ХӨНДИЙН”
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/Тусгай зөвшөөрлийн дугаар MV-020929/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн/Ч.Дамбасүрэн/

Төв аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн/С.Эрдэнэцогт/

Боловсруулсан:

Мэргэжилтэн...../А.Болор-Эрдэнэ/

2022 он

АГУУЛГА

| | |
|---|----|
| ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 2 |
| БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ | 5 |
| 2022 ОНД ЯВУУЛСАН УУЛЫН АЖИЛ..... | 7 |
| СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... | 9 |
| ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... | 18 |
| ДҮГНЭЛТ..... | 19 |

” ”

Иххэтийн амны алтны шороон орд нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэг Туул голын сав газар багтах ба МУ-020929 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны харьяалалаар Төв аймгийн Заамар сумын нутагт, Улаанбаатар хотоос баруун зүгт 240 км-г оршино.


1. MV-20929

”

/1831,77/

”

| № | Уртраг | Өргөрөг |
|---|-----------------|----------------|
| 1 | 104° 30' 51" | 48° 14' 41.81" |
| 2 | 104° 30' 51" | 48° 13' 36.81" |
| 3 | 104° 30' 1" | 48° 13' 36.81" |
| 4 | 104° 28' 40.93" | 48° 13' 45" |
| 5 | 104° 28' 40.93" | 48° 14' 41.81" |



10 ” ” ”

”

”

”

”

Заамарын нуруу нь Туул голын зүүн эрэг, ордын талбайн зүүн хэсгээр орших бөгөөд 1500-1815.5 /Цагаан уул/ метрийн үнэмлэхүй өндөртэй. Хажуу нь олон тооны гол, жалгаар хэрчигдсэн, 25-30⁰-ын налууутай /заримдаа 40⁰/. Харьцангуй өндөр нь 300-500 м юм.

Загцагийн нурууны салбар уулс Туулын голын баруун эргээр талбайн хойд талаас орж ирэх бөгөөд хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 1650 метрт хүрдэг. Харьцангуй өндөр нь 200-300 м. Олон тооны нарийн хөндий, жалгуудаар хэрчигдсэн, хажуугийн налуу нь 50° хүрдэг. Талбайн зүүн урд булангаар Аргалын нурууны салбар /зүүн хойш чиглэлтэй/ уулс орших бөгөөд 1600 м хүртэл өргөгдсөн, 100-300 м харьцангуй өндөртэй юм. Туул голын хөндий нь 1-4 км өргөнтэй, тэвш маягийн тэгш бус хэмтэй. Гольдрол нь 30-100 м өргөнтэй, 0.5-2 м гүнтэй, тахирлаж муруйсан, олон тооны арал салаа булан хар устай байдаг.

" " *Ө* " " (E-O_{2-3hr}). "

"_{2-012m}) Харьцагийн серийн доод хэсэг Заамарын свит нь Заамарын нурууны антиклиналийн төв, Цайдамын синклиналийн жигүүрээр илэрдэг.

Заамарын свитийн дээд дэд свит нь элсэн чулуу, филлитүүдийн флиш маягийн үелэл (1000м), доод дэд свит нь нарийн үеллэг элсэн чулуу, филлитийн үелэлээс (1870м) тогтоно.

" *mn*) Манлайн" давхаргадсын хурдас нь талбайн баруун хойт буланд орших Долооны грабены хэсэгт нүүрсний нарийн үеүд агуулсан алевроэлсжин, алевролитын үе бүхий хүрэн, бор саарал, хүрэн улаан, тоосгон улаан өнгийн хөрзөнгөөс бүрдэнэ. Давхаргадсын хурдас нь Цэрдийн дараах тектоник хөдөлгөөнөөр зүүн хойш чиглэлийн хүчтэй атираажилд автагдсан нь ажиглагддаг. Зузаан нь тодорхой бус, судалгааны үр дүнгээс үзэхэд хурдас нь муу судлагдсан, өгөршлийн гадаргуу нь 1м болон түүнээс дээш зузаантай байж болдог байна.

" Плейстоцены-голоцений хурдас/Q₁ – Q₂/. Судалгааны талбайд уулс хоорондын хөндий, түүний хажуу цутгалуудад өргөн тархах ба гарал үүслээр нь бэл-хажуу-бэл, голын хурдас гэж хуваадаг.

" Судалгааны талбайд тархсан гүний чулуулгийг насны хувьд дунд дээд ордовикийн настай Бороо голын бүрдэл, доод девоны магмын бүрдэл гэж хуваана.

“ “ “ “²⁻³ Үүс бүрдэлд 0
судалгаа хийсэн талбайн хамгийн эртний буюу калеодоны геосинклинал хөгжлийн икверсийн үеийн үүсэлтэй боржин-диорит-боржингийн формацийн интрузив чулуулгийг ялгав. Энэ бүрдлийн интрузив нь судалгааны талбайд хамгийн их тархсан бөгөөд ихэвчлэн боржин, боржин диоритын найрлагатай байна.

Эрлийн~~н~~ажил явуулсан талбай нь Хойд Монголын атриат системийн Тариат-Сэлэнгийн структур формацийн бүс, Монгол-Өвөр Байгалийн атриат системийн Хойд Хэнтийн структур-формацийн бүсүүдийн заагийг дамнан байрлана. Энэ хоёр структур формацийн бүс нь зүүн хойш чиглэлтэй Баянголын гүний хагарлын бүсээр хаяа нийлсэн байдаг. Структурын үндсэн бүрдэл нь доод Салеар–Каледоны, дунд герцин-мезозойн, дээд–платформын үеүүд (этаж) болно.

” ” ”

”

Төв аймгийн нутаг дэвсгэр Монгол улсын төвийн бүсэд байрладаг. Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Булган, Өвөрхангай зэрэг аймгуудтай хил залгаа оршино. Нийт 74.8 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Дэлхийн цагийн 7 дугаар бүсэд байрладаг. Нутгийн ихэнхи хэсэг нь далайн түвшнээс дээш 1000-1300 м, зүүн хойд хэсэг нь 1500-2500 м өндөрт өргөгдсөн. Хэнтий нурууны ноён оргил 2800 м өндөр Асралт хайрхан энэ бүс нутагт багтдаг. Үүнээс гадна Тосон заамар, Зоргол хайрхан зэрэг уул нурууд бий (Цэгмид, 1979).

”

Талбайн хэмжээнд усан сүлжээ нилээд сайн хөгжсөн ба хамгийн том гол нь Хараа гол юм. Хараа голын усны өргөн 3 - 6 м, гүн нь 1.0 м - ээс хэтэрдэггүй. Талбайн төв хэсгээр нь Мухар, Хүйтний голууд урсдаг.

”

Голын ус нь 10-р сарын сүүл үеэс хөлдөж, 4-р сарын эхээс гэсдэг. Өвөлдөө бага зэргийн цастай хүйтэн, зундаа бороотой халуун байх ба эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын жилийн дундаж хэм -19°C-д хүрэх бөгөөд хамгийн хүйтэн 1-р сард -37°C болж, хамгийн дулаан нь 7-р сард 35°C-д хүрнэ. Жилд унах хур тунадас дунджаар 244 мм байдаг. Салхины чиглэл хойд талаасаа зонхилох ба дунджаар 3.5 м/сек хурдтай боловч, 3 - 5 - р сард 20- 24 м/сек хүртэл хүчтэй шороон шуурга болдог.

. ”

Тус аймгийн бүс нутагт хөрсний уулын, нам уулын, ухаа-толгодын, голын татмын, зэрэг бүх шинж тохиолддог. Хөрс газарзүйн ангилалын хувьд Хангайн хөрсний их муж, түүн дотор хангайн мужид багтана. Хангайн мужид хамгийн их тархсан түгээмэл хөрс нь хүрэн хөрс юм. Хүрэн хөрсний хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, уулын хүрэн, нугын хүрэн, ойн хүрэн зэрэг хэд хэдэн дэд хэв шинж тархсан. Монгол орны ургамлын аймгийг газарзүйн байрлал, онцлогоос хамааруулан 16 ангилсан байдаг. Энэхүү ангиллаар Төв аймгийн нутаг дэвсгэрийг ургамал газарзүйн 3 тойрог дайрч

өнгөрөх ба үүнд Монгол-Дагуурын уулын ойт хээр, Хэнтийн уулын тайгын тойрог болон Дундад Халхын тойрог зэрэг юм

Ан амьтадаас буга, гөрөөс, чоно, баавгай, үнэг, хярс, дорго, тарвага, жигүүртэн амьтадаас тоодог, тогруу, ятуу, хүтүү амьдардаг бөгөөд гол горхины усанд загас, жараахай элбэг тохиолдоно.

“ ” ”

Төв аймагт 88.8 мянган хүн оршин суудаг. Аймагт 1 км² нутагт 0.8 хүн ноогдож байгаа нь улсын дундаж (1.5)-аас 0.7 пунктээр бага байгаа хэдий ч хүн амын нягтрал харьцангуй ихтэй аймгуудын тоонд ордог. Хүн амын жилийн дундаж өсөлт 1963-1969 онд 3.2% байснаа 1989-2000 онд эрс буурч -0.1% болсон нь 1990-ээд оноос хойш хүн амын төрөлт буурч, шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой тул аймагт 1990 онд 1000 хүнд ноогдох төрөлт 35.84, нас баралт 6.96, цэвэр өсөлт 28.88 байсан бол 2007 онд төрөлт 8.61, нас баралт 4.37, цэвэр өсөлт 4.24 болж буурчээ. Сүүлийн нэг жилд аймгийн хэмжээнд 1.5 мянган хүн шилжин ирж, 3.2 мянган хүн шилжин явсан байна. Аймгийн нийт хүн амын 63.69 хувь нь буюу 56347 нь хөдөлмөрийн насны хүн ам юм. Үүний 43648 (77.46%) ажиллагсад байна.

2022 ОНД ЯВУУЛСАН УУЛЫН АЖИЛ

“2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс дутуу биелүүлэлтэй ажилласан. 06 сарын 15-аас уулын ажил эхэлж 10 сарын 01-нд уулын ажил зогссон.

Тус онд ордын В’2, В’-1, В’-2 гэсэн блокуудаас нийт 1127.42 мян.м³ хөрс хуулж 44.5 мян.м³ элс олборлон баяжуулсан.

” ””

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн хойд ирмэг дагуулан түрж овоолсон. Үржил шимт хөрсний овоолгын өндрийг 1-2 м-ээр байгуулсан.

” ”

Үржил шимт хөрс хуулсаны дараа Баганаймганы хөндийн В’2, В’-1, В’-2, блокийн хөрсний чулуулгийг экскаватороор хуулан түр гадаад овоолгод шидэж, элсийг олборлосны дараа хоосон орон зай үүсмэгц дотоод овоолгоор уулын ажлыг явуулсан. Хөрс хуулалтын ажлын догол мөргөцөгийн хэмжээнүүд нь экскаваторын үзүүлэлт, хөрсний чулуулгийн шинж чанараас хамааран ТЭЗҮ-ийн дагуу авч явсан боловч геологийн өвөрмөц тогтоцоос, хананы хажуугын тогтворгүй байдал үүсэж хөрсний ажил нэмэгдсэн. Цоцгоны мухарын аманд ашиглалт явагдаагүй болно.

” ”

Элс олборлолтын догол мөргөцгийн өндөр нь элсний давхаргын зузаанаас хамаарч байна. Олборлолтын ажлыг экскаватор, автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж, элс угаан баяжуулах хэсгийн дэргэд байрлах элсний түр овоолгод овоолхоор төлөвлөв. Мөн угаасан хоосон чулуулгийг эргүүлэн ашигласан талбайд зөөж нөхөн дүүргэлт хийсэн.

Хөрсний овоолго

Ордоос 2022 онд нийт 1.4 мян.м³ үржил шимт хөрс болон 1126.02 мян.м³ хөрс хуулж, 44.5 мян.м³ элс олборлон баяжуулсан байна.

” ” ”

Шимт хөрсийг бульдозероор түрж уурхайн ирмэгийг дагуулан овоолхоор тооцлоо. Шимт хөрсний овоолгын өндрийг 1-2 м-ээр байгуулна. Энэ хөрсийг ашиглалтын эхнээс техникийн нөхөн сэргээлт хийсний дараагаар талбайн гадаргууд тарааж тэгшилсэн.

Уурхайн гадаргуугийн байгууламж, эзлэх талбай

Уурхайн гадаргуугийн ерөнхий төлөвлөгөөнд уурхайн хотхон, угаах төхөөрөмж, цэвэр бохир нуурын байрлал, авто зам зэрэг барилга байгууламжуудыг байгуулах талбайн байршилуудыг сонгов. Уурхайн хотхон, баяжуулах хэсгийн талбай, гадаад тээврийн авто замуудыг уурхайтай ердийн замаар холбоно.

Зураг 2. Уурхайн эдэлбэр газрын хэмжээ

| № | Эдэлбэр газрын нэр | Талбайн хэмжээ, га | Уурхайгаас алслагдсан зай, м |
|---|--------------------|--------------------|------------------------------|
| 1 | Уурхай | 1.8 | - |
| 2 | Хотхон | 0.5 | 100 (Баруун хойд зүгт) |
| 3 | Баяжуулах хэсэг | 0.6 | 200 (Баруун зүгт) |
| 4 | Эргэлтийн усан сан | 0.8 | 200 (Баруун зүгт) |
| 5 | Авто зам | 1 | - |
| | Нийт дүн | 4.7 | |

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

”

Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2008, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007 мөрдөн ажилласан.

| № | Хийгдсэн ажил | Хариуцах хүн | Эхний жилийн төлөвлөгөө |
|----------------------------------|---|---------------|---|
| 1 | Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байсан. | Уулын инженер | 250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийг тос, маслыг солиж байв. |
| 2 | Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услаж байна. | | 500,000төг |
| 3 | Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлсэн. | Уурхайн дарга | Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээний дүн |
| 4 | Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлсөн болно. | | Агаарын бохирдлын төлбөр 9500*12=114000 төгрөг төлсөн. |
| Нийт 557000төг зарцуулсан | | | |

Ус, усан орчин

Усны тухай хууль, Хаягдал бохир ус MNS 4943:2008, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журамыг биелүүлж ажилласан.

Уурхайн 2022 онд зарцуулсан зам усалгааны зардал

| № | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Шалгуур үзүүлэлт |
|---|--|-------------------|---|
| 1 | Заамар сумтайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан, төлбөрөө төлнө. | Компанийн захирал | Туул голын сав газартай ус ашиглах гэрээгээ байгуулан, төлбөр 40 сая төгрөг төлсөн. Усны гэрээгээ дүгнэж, 4 улиралдаа багтаан үлдэгдэл төлбөрөө төлнө |
| 2 | Унд ахуйн усаа хангадаг гүний худгандаа тоолуур тавьж баталгаажуулна. | Уурхайн дарга | Тоолуур тавигдах шатандаа явж байна |
| 3 | Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах | Уурхайн дарга | Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулсан |
| 4 | Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана. | Уурхайн дарга | Бүсийн координат болон хотхон, ахуйн бохир, хог хаягдлын байршил харуулсан зураг гаргана. |
| 5 | Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх | | Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэсэн |
| 6 | Шүүрлийн усыг дахин ашиглаж баяжуулалт, элэгдэл, эвдрэлд орсон газрын тоосжилтын ялгаралтыг бууруулах систем суурилуулах | Уурхайн дарга | Шүүрлийн усыг дахин ашиглаж баяжуулалт, элэгдэл, эвдрэлд орсон газрын тоосжилтын ялгаралтыг бууруулах систем суурилуулан. Зам усалгаа хийсэн |
| | Нийт зардал | | 2 800 000 төг |

Сөрөг нөлөөлөлийг бууруулах чиглэлээр хийсэн ажил:

- Түлш шатахуун, тослох материалууд бохир ус, химийн янз бүрийн бодисууд алдагдах, асгарах зэргээс үүдэн бага гүнд орших уст давхарга болон гадаргын усыг бохирдуулахаас сэргийлэн засварыг байгуулсан. Түлш шатахуун, тослох материалууд болон ахуйн шингэн болон хатуу хог хаягдалдаа сумын заасан цэгт хаяж төлбөрөө төлсөн.
- Гадаргын болон гүний усанд хамгаалалтын бүс тогтоож хамгаалалтын бүсэд мөрдөх журмыг чанд сахин ажилласан.
- Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн хатуу хаягдлаа ялган хаяж байсан.
- Орон нутагт хог хаягдлын төлбөрөө сум орон нутагт төлсөн болно.
- Туул голын сав газартай гэрээ хийж төлбөрөө төлсөн

- Гүний худгандаа тоолуур суурилуулан баталгаажуулсан
- Үерийн далан стандартын дагуу байгуулсан
- Хяналт шинжилгээ хийлгэсэн

. " . " "

Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай

ууль, Ойн тухай хууль, Ой хээрийн түймрээс хамгаалах тухай, Ургамал хамгааллын тухай, Байгаль орчин, Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томьёо, тодорхойлолт MNS 5914:2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915 :2008, Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008, Байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918 : 2008 биелүүлж ажиллсан.

Сөрөг нөлөөлөлийг буруулах чиглэлээр хийсэн ажил:

- Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө шимт хөрсийг 0,2- 0,3 м зузаантайгаар хуулж авна.
- Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалж байсан.
- Зам талбайг засаж, тэмдэгжүүлэн олон салаа зам гарахаас сэргийлэн хөрсний эвдрэл, газарт үүсэх сөрөг нөөлөллийг буруулах арга авсан .


. " " " " " " " "

| № | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Биелүүлсэн үзүүлэлт |
|---|--|-------------------|--|
| 1 | Газар эзэмших гэрээгээ Заамар сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх | Компанийн захирал | Гэрээ хийж, төлбөрөө төлсөн. |
| 2 | 1.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн | Уулын инженер | Нөхөн сэргээлтээ сум орон нутгийн нөхөн сэргээлт хүлээж авах комисст хүлээлгэн өгсөн |
| 3 | Шимт хөрсийг хамгаалж хэлбэршүүлэх | Уулын мастер | Шимт хөрсийг хамгаалж хэлбэршүүлсэн. |

Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт:

Манай компани нь тус онд олборлолт явуулсан 1.8 га талбайд техникээр нөхөн дүүргэлт хийж, давтан тэгшилгээ болон түрж дагтаршуулсан.


Дүйцүүлэн хамгаалах саналын дагуу орон нутгаас зааж өгсөн 5 га талбайд техникийн нөхөн дүүргэлт хийж, давтан тэгшилгээ болон түрж дагтаршуулсан.



Зураг 2. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай

Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс

Ордын ашиглалтын талбай түүний ойр орчимд түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс байхгүй болно.



Зураг 3 Замын хучилт хийж, тэмдэглэгээ хийсэн зураг

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих төлөвлөгөөний биелэлт

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 0.5 га талбайд 5000 мод тарималжуулсан.







Зураг 4 Мод тариж байгаа болон усалгаа хийж буй зураг

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрийн технологийн заавар, горим, стандарт, аюулгүй ажиллагааны шаардлага, заавар дүрмийг ажиллагсадад эзэмшүүлэх сургалтыг байнга 2022 онд 1 удаа зохион байгуулсан бөгөөд сургалтын байгаль орчны мэргэжилтэн болон Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын инженер нар хариуцан ажилласан.

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг компанийн хөдөлмөрийн гэрээг тухайн ажилтантай хийсэний дараа уг сургалтыг ганцаарчилсан болон олон нийтээр хамруулан сургалт хийдэг. Сургалтан дээр ажилчдад хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн талаарх видео үзүүлж ахуйн болон анхан шатны тусламж үзүүлэх дадлага хийлгэж дараа нь сургалтан дээр юу сурсан талаар шалгалт авч баталгаажуулдаг. Мөн өдөр шөнийн ээлжинд тухайн өдрийн ээлжийн ахлах болон ээлжийн мастер байнгын зааварчилгааг өгдөг.

Уулын болон үйл ажиллагааны явцад ажлын байран дээрх Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа байгаль орчин эрүүл ахуйн үзлэгт шалгалтыг явуулж ямар алдаа дутагдал байгааг газар дээр нь засч залруулж асуудлыг тухайн мастер механикч болон ээлжийн ахлахад мэдэгдэж аюулгүй ажиллагааны дүн шинжилгээ хийж ахиж давтагдахгүй байлгах тал дээр ээлжийн болон мастер механиктай хамтран ажиллаж шаардлагатай гэж үзвэл уг ажилтанд зохих арга хэмжээ авдаг.

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, байгаль орчин, эрүүл ахуйн сургалт зааварчилгааг сар тутам явуулж засвар үйлчилгээ болон угаах төхөөрөмж уулын ашиглалтын талбайд 7 хоног бүр хийдэг.

Мөн болзошгүй аваар, осолын үед хэрэглэх анхны тусламжын материал(өвчин намдаах эм, ариутгасан спирт, цэвэр боолт гэх мэт)-ыг байнгын бэлэн байдалд байлгахыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, эрүүл ахуйн мэргэжилтэн нар хариуцан ажилладаг.



Зураг 5. Сургалт явуулж буй зураг

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд манай компани хог хаягдлаа нэгдсэн нэг цэгт төвлөрүүлэн хурааж Заамар сумын хог хаягдлын цэгт зөөвөрлөн хаясан.

Мөн тамхи татах цэг, хогийн савыг 2 байрны дунд байрлуулсан бөгөөд өдөр бүр баяжуулах хэсгийн ажилтнуудаар ээлжээр уурхайн хотхон орчмын жижиг хог хаягдлыг түүн цэвэрлүүлдэг.



Зураг 6. Хог хаягдлын цэг

ДҮГНЭЛТ

“Эрд хул” ХХК-ийн ашиглалт явуулсан ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт МҮ-020929 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн талбайд оршино.

2022 онд хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул тухайн жилийн төлөвлөгөөнөөс хожуу 06 сарын 15-наас үйл ажиллагаа эхлүүлж 10 дугаар сарын 01-ийг дуустал хугацаанд өдөрт 10 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр уулын ажлыг зохион байгуулсан.

Тус онд ордын В’2, В’-1, В’-2 гэсэн блокуудаас нийт 1127.42 мян.м³ хөрс хуулж 44.5 мян.м³ элс олборлон баяжуулсан.

Манай компани нь тус онд олборлолт явуулсан 1.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Дүйцүүлэн хамгаалах саналын дагуу орон нутгаас зааж өгсөн 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 0.5 га талбайд 5000 мод тарималжуулсан.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн арга хэмжээний хүрээнд “Туул голын бохирдол” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Мөн хог хаягдлын Заамар сумтай гэрээ байгуулан хамтран ажиллдаг бөгөөд хогийн цэгийг уурхайн тосгоны зүүн талд байгуулж түүндээ хог хаягдлаа булшилан, хураадаг хогын цэгт байршуулдаг.